



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2018.08.06 № 35

Асуулга тавих тухай

УИХ -ын гишүүн миний бие өмнө нь Орхон аймгийн Эрдэнэт хотоос сонгогдсон гишүүний хувьд "Жаст групп" ХХК нь "Эрдэнэт үйлдвэр" ХХК -ийн төрийн өмчлөлийн 51%-ийг зээлийн баталгаа гаргаж, Өмнөд Африкийн Стандарт банкнаас зээл авсан тухай асуудлыг анхааралтай судалж байр сууриа илэрхийлсээр ирсэн болно.

Түүнчлэн Ардчилсан намын бүлгээс 2018 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр УИХ -ын даргад ажлын хэсэг байгуулах хүсэлт тавьсны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 4 дүгээр сарын 13 -ны өдөр 77 дугаар захирамж гарч Ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Я.Санжмятав, ажлын хэсгийн дэд ахлагчаар Т. Аюурсайхан нар ажиллаж байна.

Миний бие Монгол Улсын Их Хурлын хаврын чуулганы хаалтын хуралдааны үеэр тухайн ажлын хэсгээс "Эрдэнэт үйлдвэр" ХХК баталгаа гаргаж Өмнөд Африкийн Стандарт банкнаас зээл авсан, түүнтэй холбоотой Олон улсын шүүхийн шийдвэр, ажлын хэсгийн үр дүнгийн талаар асуулт тавихад Ажлын хэсгийн ахлагч Я.Санжмятав "2018 оны 7 дугаар сарын 6 -ны өдөр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын нийслэл Лондон хотод Арбитрын шүүх хурал болох бөгөөд уг шүүх хуралд ажлын хэсгийн гишүүдээс төлөөлүүлэн хүн оролцуулах гэж байгаа, тухайн шүүх хурлаас гарах шийдвэр, үр дүн нь Монгол Улс, цаашлаад Эрдэнэт үйлдвэрийн хувь заяатай шууд хамааралтай тухай" мэдээллийг өгч байсан билээ.

Иймээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 -т заасны дагуу УИХ -ын бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Танд тавьж байна. Үүнд:

1. Жаст групп ХХК нь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн төрийн өмчлөлийн 51% -ийг зээлийн баталгаа гаргаж Өмнөд Африкийн Стандарт банкнаас зээл авсан гэх асуудал Английн Арбитрын шүүхээр өнөөгийн байдлаар бүрэн эцэслэн шийдвэрлэгдсэн эсэх;
2. Арбитрын шүүхээс Эрдэнэт үйлдвэрийн удирдлагууд болон компанийн өмч хөрөнгө, үйл ажиллагаатай холбоотой ямар шийдвэр гарсан. Тухайн шийдвэрийн үр дүнг хэрхэн үзэж байгаа талаар;

0000000082

3. Монгол улсад онц их хэмжээний хохирол учруулж, Эрдэнэт үйлдвэрийг өрөнд оруулсан этгээдүүдэд ямар арга хэмжээ авах гэж байгаа талаар болон Эрдэнэт үйлдвэрийг хохиролгүй болгох талаар төлөвлөгөө, төсөл боловсруулсан эсэх зэрэг асуудлуудыг тодорхой болгон хариу ирүүлэх.

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы ээлжит болон ээлжит бус чуулганаар нэн яаралтай горимоор сонсгохыг танаас хүсье.

Хүндэтгэсэн:

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.БААСАНХҮҮ